

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

1 Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/239
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Соёл, урлагийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл, урлагийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Соёл, урлагийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Соёл, урлагийн газрын дарга Г.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлагийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 03-наас 2019 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар Аудит ХХК-ийн аудитор М.Энхжаргал ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл, урлагийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн № 01/26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Соёл, урлагийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Соёл, урлагын газар нь “Соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжсэн үндэсний онцлог бүхий үйл ажиллагааг олон улсад шалгарсан, шинэлэг менежмент, туршлагыг ашиглан иргэн бүрт хүргэх, соёлоор дамжуулан Монгол хүний амьдралын чанарыг сайжруулж, нийгэм эдийн засгийн хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дүгээр тушаалаар Соёл, урлагийн газар нь Улсын хэмжээнд соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй байгууллага байна.

Соёл, урлагийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Соёл, урлагийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга боловсруулж байна.

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Соёл, урлагийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Соёл, урлагийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acobous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Соёл, урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Соёл, урлагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн нийт орлогыг сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллагын үйл ажиллагааг илүү сайн илэрхийлж чадах үзүүлэлт гэж үзсэн.

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн *нийт орлого* 1,602,127.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 16,021.27 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав. Үүнд:

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	500.8	
	Дүн	2	500.8	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар улс, орон нутгийн сан хөмрөгийн тооллого зохион байгуулах ажилд шаардагдах зардлын хэрэгжилтийг нарийвчлан судлах

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Соёл, урлагийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1,066,437.0 төсөв батлагдаж, дээд шатны төсвийн захирагчаас 532,300.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт гүйцэтгэл 1,052,529.2 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь төсөв хэтрээгүй батлагдсан төсвийн хүрээнд ажиллажээ.

Нэмэлт санхүүжилтээр орсон 532,300.0 мянган төгрөгийг Соёлын биет бус өвийн их наадамд 346,387.8 мянга, Түүхийн хүрд 2018 оны баримтат киноны зардалд 108,900.0 мянган төгрөг, Үндэсний бичиг үсгийн баярын зардалд 2,000.0 мянга, Даяаршлын түрлэг дэх Монгол Улсын өвийн дархлаа сэдэвт зөвөлгөөнд 10,000.0 мянга, Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт дэлхийн өвийн эмблем, танилцуулга бүхий чулуу байршуулах зардалд 15,000.0 мянга, Номын баяр 2018 наадамд 10,000.0 мянга, Шилдэг уран бүтээл уран бүтээлч шалгаруулах улсын IV уралдаанд 40,012.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Соёл урлагийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансанд нийт 107 удаагийн төсөв, гүйцэтгэлээр 7 удаа, цалингийн зардлаас бусад таван саяаас дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг 7 удаа шивж байршуулсан байна. Харин бусад 93 удаагийн байршуулах 5,352,450.0 мянган төгрөгийн мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хоёр зөвлөмж өгсөн бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл, урлагийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Соёл, урлагийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Бараа ажил үйлчилгээ худалдан авах талаар

3.1.1 Илрүүлэлт:

Тус газарт БСШУСС-ын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/727 тоот тушаалаар Монгол Улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч буй түүхэн, тэмдэглэлт, үйл явдлыг баримтжуулах, архивлан хадгалах зорилгоор 2018 оны Түүхийн хүрд баримтад кино бүтээхэд шаардлагатай зардлыг олгосон байна. Үүнийг Соёл, урлагийн газар нь Монгол Кино ТӨҮГ-тай шууд гэрээ байгуулан киноны зардлыг олгосон бөгөөд тухайн ажил, үйлчилгээнд тендер зарлаагүй, хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, гэрээ дүгнэсэн акт, ажил хүлээлгэн өгсөн баримт байхгүй байна.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 7 дугаар зүйл "худалдан авах ажиллагааны журам", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Зардлын зүйл ангиудыг батлагдсанаас зөрүүтэй зарцуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэх.
- Ажлын хэсэг байгуулан Түүхийн хүрд баримтад киноны агуулга, хэмжээ, чанар, үр дүнгийн талаарх дүгнэлт гаргуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлд тусгасан зөрчлийг зөвшөөрч байна

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Авлагыг тулган шалгахад харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, акт үйлдсэн бөгөөд харилцагч Нийгмийн даатгалын байгууллагад 500.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Авлагыг санхүүгийн тайланд бүртгээгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, харилцагч тус бүрээр авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулан, авлагаа барагдуулж, авлага, өглөг үүсгэхгүй ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлд тусгасан зөрчлийг зөвшөөрч байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,542,291.80</u>	<u>1,919,822.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	10,502.80	500,833.00
335	Бусад авлага	10,502.80	500,833.00
3351	Байгууллагаас авах авлага	10,502.80	500,833.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,531,789.00	1,418,989.00
354	Хангамжийн материал	1,531,789.00	1,418,989.00
35410	Бичиг хэргийн материал	623,800.00	511,000.00
35420	Аж ахуйн материал	907,989.00	907,989.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,456,106.72</u>	<u>23,412,859.20</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,456,106.72	23,412,859.20
392	Биет хөрөнгө	21,777,773.35	22,713,900.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,318,931.28	42,722,002.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,499,765.42	-29,539,908.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,071,328.74	29,471,128.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,112,721.25	-19,939,321.33
393	Биет бус хөрөнгө	678,333.37	698,958.39
39301	Програм хангамж	880,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-201,666.63	-456,041.61
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>23,998,398.52</u>	<u>25,332,681.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>23,998,398.52</u>	<u>25,332,681.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	23,998,398.52	25,332,681.20
512	Хуримтлагдсан үр дүн	23,998,398.52	25,332,681.20
51210	Өмнөх үеийн үр дүн	23,998,398.52	23,998,398.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,334,282.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>23,998,398.52</u>	<u>25,332,681.20</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	757,789,227.31	1,602,126,990.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,790,427.31	3,389,890.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,790,427.31	3,389,890.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,790,427.31	3,389,890.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,790,427.31	3,389,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,998,800.00	1,598,737,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	288,124,800.00	1,066,437,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	288,124,800.00	1,066,437,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	444,874,000.00	532,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	444,874,000.00	532,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	733,790,828.79	1,600,792,707.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	595,672,409.79	1,556,884,788.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,672,409.79	1,556,884,788.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,759,897.20	194,847,602.80
210101	Үндсэн цалин	156,863,940.20	169,490,605.80
210102	Нэмэгдэл	5,890,800.00	25,356,997.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,005,157.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,946,911.00	23,178,267.00
210201	Тэтгэврийн даатгал	12,487,819.00	16,399,367.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,727,650.00	1,694,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,382,119.00	1,355,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	308,024.00	338,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,041,299.00	3,389,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,812,251.00	26,721,200.00
210401	Бичиг хэрэг	2,693,340.00	3,547,730.00
210402	Тээвэр, шатахуун	10,336,296.00	15,911,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,649,715.00	5,927,288.00
210404	Ном, хэвлэл	31,885,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,247,900.00	1,335,005.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	911,900.00	571,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	571,400.00
210604	Урсгал засвар	911,900.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	4,855,125.00	5,620,000.00
210702	Дотоод албан томилолт	4,855,125.00	5,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	298,280,705.00	1,168,175,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	298,120,705.00	1,168,175,200.00

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	160,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,105,620.59	137,771,118.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	123,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,100,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,005,620.59	14,121,118.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,118,419.00	43,907,919.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,843,326.00	30,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	30,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,393,326.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	107,450,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,275,093.00	13,907,919.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,275,093.00	13,907,919.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>23,998,398.52</u>	<u>1,334,282.68</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>23,998,398.52</u>	<u>1,334,282.68</u>

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	753,833,383.00	1,598,737,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,834,583.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,834,583.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,834,583.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,834,583.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,998,800.00	1,598,737,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	288,124,800.00	1,066,437,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	288,124,800.00	1,066,437,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	444,874,000.00	532,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	444,874,000.00	532,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	746,162,083.00	1,587,049,119.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	746,162,083.00	1,587,049,119.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	608,043,664.00	1,543,141,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171,770,400.00	194,837,100.00
210101	Үндсэн цалин	147,770,800.00	169,480,100.00
210102	Нэмэгдэл	11,781,000.00	25,357,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,218,600.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,946,911.00	23,679,100.00
210201	Тэтгэврийн даатгал	14,878,119.00	16,900,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	968,620.00	1,694,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,282.00	1,355,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	215,610.00	338,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,078,280.00	3,389,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,323,851.00	26,608,400.00
210401	Бичиг хэрэг	3,204,940.00	3,434,930.00
210402	Тээвэр, шатахуун	10,336,296.00	15,911,177.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,649,715.00	5,927,288.00
210404	Ном, хэвлэл	31,885,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,247,900.00	1,335,005.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	911,900.00	571,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	571,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,855,125.00	5,620,000.00
210702	Дотоод албан томилолт	4,855,125.00	5,620,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	297,470,894.00	1,168,175,200.00

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	297,310,894.00	1,168,175,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,764,583.00	123,650,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,834,583.00	123,650,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,930,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138,118,419.00	43,907,919.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,843,326.00	30,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	30,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,393,326.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	107,450,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,275,093.00	13,907,919.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,275,093.00	13,907,919.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,671,300.00</u>	<u>11,687,981.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,671,300.00	11,687,981.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,671,300.00	11,687,981.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,671,300.00	11,687,981.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,671,300.00	11,687,981.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-7,671,300.00</u>	<u>-11,687,981.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	23,998,398.52	23,998,398.52
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	23,998,398.52	23,998,398.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	23,998,398.52	23,998,398.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,334,282.68	1,334,282.68
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	25,332,681.20	25,332,681.20

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,066,437,100.00	1,052,529,181.00	13,907,919.00	98.70
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,066,437,100.00	1,052,529,181.00	13,907,919.00	98.70
Бараа, үйлчилгээний зардал	1,036,437,100.00	1,022,529,181.00	13,907,919.00	98.66
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,837,100.00	194,837,100.00	-	100.00
Үндсэн цалин	169,480,100.00	169,480,100.00	-	100.00
Нэмэгдэл	25,357,000.00	25,357,000.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,679,100.00	23,679,100.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	16,900,200.00	16,900,200.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	1,694,700.00	1,694,700.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	1,355,800.00	1,355,800.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	338,900.00	338,900.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	3,389,500.00	3,389,500.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	26,608,400.00	26,608,400.00	-	100.00
Бичиг хэрэг	5,760,000.00	3,434,930.00	2,325,070.00	59.63
Тээвэр (шатахуун)	13,315,200.00	15,911,177.00	(2,595,977.00)	119.50
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,033,200.00	5,927,288.00	105,912.00	98.24
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,335,005.00	164,995.00	89.00
Эд хогшил худалдан авах	12,027,300.00	11,984,381.00	42,919.00	99.64
Багаж, техник, хэрэгсэл	8,017,300.00	10,584,581.00	(2,567,281.00)	132.02
Тавилга	1,510,000.00	1,399,800.00	110,200.00	92.70
Урсгал засвар	2,500,000.00	-	2,500,000.00	-
Томилолт, зочны зардал	5,620,000.00	5,620,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	5,620,000.00	5,620,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	650,015,200.00	636,150,200.00	13,865,000.00	97.87
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650,015,200.00	636,150,200.00	13,865,000.00	97.87
Бараа үйлчилгээний бусад зардал	123,650,000.00	123,650,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	123,650,000.00	123,650,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	30,000,000.00	30,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,066,437,100.00	1,052,529,181.00	13,907,919.00	98.70
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,066,437,100.00	1,052,529,181.00	13,907,919.00	98.70
Улсын төсвөөс санхүүжих	1,066,437,100.00	1,052,529,181.00	13,907,919.00	98.70

Соёл, урлагийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	17.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00

4.1 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
Бараа, үйлчилгээний зардал	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
Нэмэлт санхүүжилтийн орлого	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	532,300,000.00	532,300,000.00	00.00	100%

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.02.20	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Аудитын код:	САГ-2019/70/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Соёл урлагийн газар			Мянган төгрөгөөр	

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Тус газарт БСШУСС-ын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/727 тоот тушаалтай Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарч буй түүхэн, тэмдэглэлт, үйл явдлыг баримтжуулах, архивлан хадгалах зорилгоор 2018 оны Түүхийн хүрд баримтад кино бүтээх шаардлагатай зардлыг олгосон байна. Үүнийг Соёл урлагийн газар нь Монгол Кино ТӨҮГ-тай шууд гэрээ байгуулан киноны зардлыг олгосон бөгөөд тухайн ажил, үйлчилгээнд тендер зарлаагүй, хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, гэрээ дүгнэсэн акт, ажил хүлээлгэн өгсөн баримт байхгүй байна.	0	Зөвлөмж өгөх	Соёлын өв, өвийн хэлтсийн дарга	Г.Батхуяг
Авлагыг тулган шалгахад харилцагч байгуулагуудтай тооцоо нийлж, акт үйлдсэн бөгөөд харилцагч Нийгмийн даатгалын байгууллагад 500,8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэн байна.	500.8	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	А.Түвшин
Дүн	500.8			

